



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/38/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор:                      М.Алтантуяа Утас: 99890393      Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН Г  
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Д.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

2021.02.5 № 2/67

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 97 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

2021 А4 ТООТ

• 005021030

Газрын харилцаа, кадастрын асуудлыг аймгийн Засаг даргад, барилгын захиалагчийн хяналт асуудлыг холбогдох агентлагийн өмнө хариуцан тайлагнадаг байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Аудитын гол асуудал**

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 169 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны 03/1690 тоот албан бичгээр захиалагчийн техник хяналтын зардлаас 127,7 сая төгрөгийн үнийн дээд хязгаарт багтаан суудлын автомашин худалдан авах зөвшөөрөл олгосны дагуу Аймгийн Засаг даргын 2020.05.19-ны өдрийн А/348 тоот захирамжаар Орон нутгийн өмчийн газраас 2020.05.25, 2020.06.26-ны өдөр тус тус зарласан 127,7 сая төгрөгийн автомашин худалдан авах тендер амжилтгүй болсон бөгөөд;

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дээрх тогтоолыг зөрчин Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас 2020.10.22-нд 643 тоот албан бичгээр аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст захиалагчийн техник хяналтын зардлаас 20,0 сая төгрөг нэмж гаргуулах хүсэлт өгсөн;
- Хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2020.10.23-ны өдрийн А/694 тоот захирамжаар 20.0 сая төгрөгийг нэмж нийт 147,7 сая төгрөгөөр худалдан авах зөвшөөрөл гаргуулан худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , 14.1."Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна;" , 14.1.8."Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;" , 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" , Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4 дүгээр зүйлийн 30.4.1 "Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;" тухай заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,383,039.42</b>	<b>46,286,363.42</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	5,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	5,500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	36,383,039.42	40,786,363.42
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	55,346.00	55,346.00
35410	Бичиг хэргийн материал	36,327,693.42	40,731,017.42
35420	Аж ахуйн материал	1,480,750.00	2,290,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,397,500.00	7,742,300.00
35440	Түлш, шатах тослох материал	2,980,000.00	5,250,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,958,072.42	1,200,087.42
		22,511,371.00	24,247,930.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>304,851,071.02</b>	<b>470,916,942.08</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>304,851,071.02</b>	<b>470,916,942.08</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		
39201	Барилга, байгууламж, орон сууц	282,120,737.84	448,362,608.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	195,394,386.72	195,394,386.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-5,494,289.11	-10,195,244.83
39204	Хуримтлагдсан элэгдэл	92,491,750.00	240,191,750.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-85,825,083.36	-91,594,527.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	316,859,092.31	374,037,949.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-244,154,231.58	-273,873,273.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	27,877,773.00	31,287,773.00
		-15,028,660.14	-16,886,203.60
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		
39301	Программ хангамж	22,730,333.18	22,554,333.14
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,790,000.00	1,790,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	-1,584,666.82	-1,760,666.86
		22,525,000.00	22,525,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>341,234,110.44</b>	<b>517,203,305.50</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>341,234,110.44</b>	<b>517,203,305.50</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>341,234,110.44</b>	<b>517,203,305.50</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	328,802,027.70	328,802,027.70
		328,802,027.70	328,802,027.70
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	-51,373,872.53	124,595,322.53
51220	Тайлант үеийн үр дүн	-25,454,040.67	-51,373,872.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-25,919,831.86	175,969,195.06
		63,805,955.27	63,805,955.27
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>341,234,110.44</b>	<b>517,203,305.50</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>734,571,118.00</b>	<b>1,444,172,299.65</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>95,132,050.00</b>	<b>630,522,937.67</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	95,132,050.00	630,522,937.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,132,050.00	630,522,937.67
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,360,550.00	569,223,244.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,771,500.00	61,299,693.67
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>639,439,068.00</b>	<b>813,649,361.98</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>462,356,700.00</b>	<b>552,280,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	462,356,700.00	552,280,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>145,789,468.00</b>	<b>232,575,861.98</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135,789,468.00	227,575,861.98
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>31,292,900.00</b>	<b>28,792,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,292,900.00	28,792,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>760,490,949.86</b>	<b>1,268,203,104.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>760,490,949.86</b>	<b>1,268,203,104.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>684,539,084.86</b>	<b>614,089,614.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>363,504,199.00</b>	<b>410,119,119.91</b>
210101	Үндсэн цалин	363,504,199.00	297,324,521.66
210102	Нэмэгдэл	00.00	90,167,945.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,880,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,746,553.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,600,989.00</b>	<b>51,047,546.51</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,886,008.00	34,814,947.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,802,081.00	4,058,200.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	243,400.00	3,246,499.68
210204	Ажилгүйдлийн даатгал	60,900.00	811,599.69
210205	Эрүүл мэндийн даатгал	608,600.00	8,116,299.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,939,729.00</b>	<b>21,212,513.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,174,209.00	2,425,496.00
210302	Түлш, халаалт	18,340,560.00	16,351,057.00
210303	Цэвэр, бохир ус	2,424,960.00	2,435,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,253,971.00</b>	<b>22,535,181.00</b>
210401	Бичиг хэрэг	1,572,600.00	5,649,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,313,115.00	11,843,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	555,661.00	479,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	857,000.00	1,337,400.00
210408	Бараа материал акталсны зардал	13,965,495.00	3,226,031.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>396,000.00</b>	<b>396,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>00.00</b>
210604	Урсгал засвар	8,000,000.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,333,000.00</b>	<b>4,747,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,333,000.00	4,747,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>95,933,863.00</b>	<b>27,367,689.98</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,349,263.00	26,787,661.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	268,900.00	268,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	216,700.00	212,128.00

**Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,577,333.86	76,664,563.61
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,336,094.00	34,441,577.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,241,239.86</b>	<b>42,222,985.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>75,951,865.00</b>	<b>654,113,490.58</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,792,600.00	15,524,111.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	39,902.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,240,000.00	3,341,609.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,552,600.00</b>	<b>12,142,600.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,360,550.00	544,723,244.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>59,360,550.00</b>	<b>544,649,244.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,653,171.00	7,580,387.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	353,171.00	7,580,387.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,300,000.00</b>	<b>74,000.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,544.00	86,285,748.58
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	145,544.00	16,285,748.58
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>70,000,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-25,919,831.86</b>	<b>175,969,195.06</b>
		<b>-25,919,831.86</b>	<b>175,969,195.06</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>		
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>698,799,618.00</b>	<b>1,382,872,605.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>59,360,550.00</b>	<b>569,223,244.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,360,550.00	569,223,244.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,360,550.00	569,223,244.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>639,439,068.00</b>	<b>813,649,361.98</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>462,356,700.00</b>	<b>552,280,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	462,356,700.00	552,280,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>145,789,468.00</b>	<b>232,575,861.98</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	3,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135,268,446.00	227,575,861.98
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>31,292,900.00</b>	<b>28,792,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,292,900.00	28,792,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>671,724,118.00</b>	<b>1,222,376,605.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>671,724,118.00</b>	<b>1,222,376,605.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>595,772,253.00</b>	<b>568,164,626.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>364,100,156.00</b>	<b>407,286,773.66</b>
210101	Үндсэн цалин	269,556,156.00	298,133,221.95
210102	Нэмэгдэл	72,162,300.00	86,526,898.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,539,985.00	10,880,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,841,715.00	11,746,553.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,524,700.00</b>	<b>52,329,354.76</b>

**Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210201	Тэтгэврийн даатгал	30,954,278.00	36,096,755.27
210202	Тэтгэмжийн даатгал	3,642,000.00	4,058,200.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,913,600.00	3,246,499.68
210204	Ажилгүйдлийн даатгал	730,822.00	811,599.69
210205	Эрүүл мэндийн даатгал	7,284,000.00	8,116,299.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		
210301	Гэрэл, цахилгаан	22,939,729.00	21,212,513.00
210302	Түлш, халаалт	2,174,209.00	2,425,496.00
210303	Цэвэр, бохир ус	18,340,560.00	16,351,057.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		
210401	Бичиг хэрэг	7,741,100.00	19,281,950.00
210402	Тээвэр, шатахуун	1,145,500.00	5,649,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,705,800.00	11,843,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	455,500.00	455,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,434,300.00	1,334,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		
210604	Урсгал засвар	396,000.00	396,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,333,000.00	4,747,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,333,000.00	4,747,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	111,986,568.00	31,225,189.98
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	111,401,968.00	30,645,161.98
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,000.00	99,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	268,900.00	268,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	216,700.00	212,128.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,751,000.00	31,685,845.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,751,000.00	31,685,845.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,951,865.00	654,211,979.58
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,792,600.00	15,622,600.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	2,240,000.00	3,480,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,552,600.00	12,142,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
		59,360,550.00	544,649,244.00
		10,653,171.00	7,654,387.00
		353,171.00	7,580,387.00
		10,300,000.00	00.00
		145,544.00	86,285,748.58
		145,544.00	16,285,748.58
		00.00	70,000,000.00
		<b>27,075,500.00</b>	<b>160,496,000.00</b>
		<b>27,075,500.00</b>	<b>160,496,000.00</b>
		<b>27,075,500.00</b>	<b>160,496,000.00</b>
		27,075,500.00	160,496,000.00
		27,075,500.00	160,496,000.00
		<b>-27,075,500.00</b>	<b>-160,496,000.00</b>
		00.00	00.00
		00.00	00.00
		00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	-25,454,040.67	367,153,942.30
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	-25,454,040.67	367,153,942.30
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,919,831.86	-25,919,831.86
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	-51,373,872.53	341,234,110.44
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	-51,373,872.53	341,234,110.44
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	-51,373,872.53	341,234,110.44
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	175,969,195.06	175,969,195.06
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	328,802,027.70	63,805,955.27	124,595,322.53	517,203,305.50

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	581,073,500.00	557,207,364.42	23,866,135.58	95.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581,073,500.00	557,207,364.42	23,866,135.58	95.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	565,450,900.00	541,584,764.42	23,866,135.58	95.8%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,478,500.00	406,478,073.66	426.34	100.0%
210101	Үндсэн цалин	296,321,300.00	297,324,521.95	-1,003,221.95	100.3%
210102	Нэмэгдэл	86,526,900.00	86,526,898.71	1.29	100.0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,880,100.00	10,880,100.00	0.00	100.0%
210105	Гэрээт ажлын хөлс	12,750,200.00	11,746,553.00	1,003,647.00	92.1%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,784,900.00	53,169,354.76	1,615,545.24	97.1%
210201	Тэтгэврийн даатгал	38,552,300.00	36,936,755.27	1,615,544.73	95.8%
210202	Тэтгэмжийн даатгал	4,058,200.00	4,058,200.37	-0.37	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,246,500.00	3,246,499.68	0.32	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	811,600.00	811,599.69	0.31	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	8,116,300.00	8,116,299.75	0.25	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,215,400.00	21,212,513.00	2,002,887.00	91.4%
210301	Гэрэл, цахилгаан	3,280,000.00	2,425,496.00	854,504.00	73.9%
210302	Түлш, халаалт	17,475,400.00	16,351,057.00	1,124,343.00	93.6%
210303	Цэвэр, бохир ус	2,460,000.00	2,435,960.00	24,040.00	99.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	20,334,400.00	19,281,950.00	1,052,450.00	94.8%
210401	Бичиг хэрэг	5,649,000.00	5,649,000.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	12,895,600.00	11,843,150.00	1,052,450.00	91.8%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	455,500.00	455,500.00	0.00	100.0%

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,334,300.00	1,334,300.00	0.00	100.0%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>396,000.00</b>	<b>396,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00	0.00	100.0%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,577,500.00</b>	<b>00.00</b>	<b>5,577,500.00</b>	<b>0.0%</b>
210604	Урсгал засвар	5,577,500.00	00.00	5,577,500.00	0.0%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,340,600.00</b>	<b>4,747,000.00</b>	<b>13,593,600.00</b>	<b>25.9%</b>
210702	Дотоод албан томилолт	18,340,600.00	4,747,000.00	13,593,600.00	25.9%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>584,600.00</b>	<b>580,028.00</b>	<b>4,572.00</b>	<b>99.2%</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00	0.00	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	268,900.00	268,900.00	0.00	100.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	216,700.00	212,128.00	4,572.00	97.9%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35739000.00</b>	<b>35719845.00</b>	<b>19,155.00</b>	<b>99.9%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,739,000.00	35,719,845.00	19,155.00	99.9%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15622600.00</b>	<b>15622600.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,622,600.00</b>	<b>15,622,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,480,000.00	3,480,000.00	0.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,142,600.00	12,142,600.00	0.00	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>581,073,500.00</b>	<b>557,207,364.42</b>	<b>23,866,135.58</b>	<b>95.9%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>552,280,600.00</b>	<b>535,994,851.42</b>	<b>16,285,748.58</b>	<b>97.1%</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	552,280,600.00	535,994,851.42	16,285,748.58	97.1%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>28,792,900.00</b>	<b>21,212,513.00</b>	<b>7,580,387.00</b>	<b>73.7%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	28,792,900.00	21,212,513.00	7,580,387.00	73.7%
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>38.00</b>	<b>38.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	0.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	0.00	100.0%
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00	0.00	100.0%
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>38.00</b>	<b>38.00</b>	<b>0.00</b>	<b>100.0%</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34.00	34.00	0.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	04.00	04.00	0.00	100.0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>118695568.00</b>	<b>232,575,861.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>118695568.00</b>	<b>232,575,861.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>118695568.00</b>	232,575,861.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	<b>118695568.00</b>	187,075,861.98
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>45,500,000.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		45,426,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		74,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	88,200,068.00	232575861.98
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	88,200,068.00	232,575,861.98
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23073296.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47881572.00	3,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17245200.00	227,575,861.98
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Д.Алтангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 18-аас 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 642 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Баянхонгор аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, түүнд нийцүүлэн хот байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажлыг зохион байгуулах Улсын болон орон нутгийн хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламжид их засварын ажилд техникийн болон захиалагчийн хяналт хийх, барилгын материалуудад лабораторийн сорилт шинжилгээ хийж баталгаажуулах гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Тээврийн хэрэгслийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Газрын тухай хууль

### 3.3 Нягтлан БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2020.09.22-ны өдрийн А/221 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг ГХБХБГ-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж тайланг ирүүлсэн, Баянхонгор аймгийн ХОХБТХ-ийн даргын 2020.09.17-ны өдрийн ГХБХБГ-ын дэргэдэх дотоод хяналтын зөвлөлийн ажлын төлөвлөгөөний дагуу дотоод хяналтыг хийж хяналт шалгалт хийж ажлын тайлан, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн арилгах зөвлөмжийг тус тус ирүүлсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 724127.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 14482.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1268203.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 25364.0 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 175969.2 мянган төгрөгөөр буюу 51,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Б			
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>			
Мөнгөн хөрөнгө	36,383.0	46,286.4	9,903.3
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	5,500.0	5,500.0
Бараа материал	-	-	-
	36,383.0	40,786.4	4,403.3
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>			
Үндсэн хөрөнгө	304,851.1	470,916.9	166,065.9
Хуримтлагдсан элэгдэл	656,938.0	865,226.9	208,288.9
	(352,086.9)	(394,309.9)	(42,223.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>341,234.1</b>	<b>517,203.3</b>	<b>175,969.2</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	341,234.1	517,203.3	175,969.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>341,234.1</b>	<b>517,203.3</b>	<b>175,969.2</b>

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тайлант онд автомашины тендерт шалгарсан Индранил-Очир ХХК-нд 2020.08.26-нд урьдчилгаа санхүүжилтэд 60500.0 мянган төгрөг олгосон ба нийлүүлсэн автомашин тендерийн техникийн шаардлага хангаагүй тул тендерийг цуцалснаас 2020.10.28-ны өдөр 55000.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар орж тайлант хугацааны эцэст 5500.0 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 40786.4 мянган төгрөг болж өмнөх оноос 4403.3 мянган төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгсэл 2270.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2133.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 865226.9 мянган төгрөг болж өмнөх оноос 208288.9 мянган төгрөгөөр өссөн нь 147700.0 мянган төгрөгөөр захиалагчийн хяналтын зардлаас суудлын автомашин, 8730.7 мянган төгрөгийн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр 4065.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч АЗДТГ-аас 37400.0 мянган төгрөгийн GPS тоног төхөөрөмж, "AVSF" төслөөс 10392.8 мянган төгрөгийн зургийн аппарат, өнгөт принтер үнэ төлбөргүй орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 517203.3 мянган төгрөг ба өмнөх оноос 175969.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Нийт орлого 1444172.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оныхоос 709601.2 мянган төгрөгөөр өссөн нь 2020 оноос газрын дуудлага худалдааны орлогыг тус байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан төвлөрүүлдэг болсонтой холбоотой ба үндсэн үйл ажиллагааны орлого /дуудлага худалдаа, газрын үнэ, гэрчилгээ, хувийн хэргийн үнэ/ 569223.2 мянган төгрөг, барилга захиалагчийн хяналтын зардлаас орсон орлого 227575.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хөрөнгө, бараа материал хүлээн авсан орлого 61299.7 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Нийт зардал 1268203,1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 507712,1 мянган төгрөгөөр буюу 66.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал 52061.5 мянган төгрөгөөр өссөн ба төвлөрүүлэх шилжүүлэг 568430.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүжилт, орлого төвлөрүүлэлтийг харуулав.

Дансны нэр	Тусгай зориулалтын шилжүүлгээр	Орон нутгийн төсвөөс	Үндсэн үйл ажиллагааны орлого/газрын дуудлага худалдааны орлого/	Захиалагчийн хяналтын зардал	ЗД-ын нөөц хөрөнгөөс	ГЗБГЗЗГ	Нийт орлого, санхүүжилт
Үндсэн дансаар	552,281	28,793	244,872	0	0	0	825,945
Нэмэлт санхүүжилтийн дансаар	0	0	324,351	227,576	2,000	3,000	556,927
Нийт мөнгөн орлого	0	0	0	0	0	0	1,382,873
Төвлөрүүлэлт	16,286	7,654	544,649	0	0	0	568,589
Төвлөрүүлэлт /ГЗБГЗЗГ/	0	0	24,500	45,500	0	0	70,000
Нийт төвлөрүүлэлт	0	0	0	0	0	0	638,589

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 792738.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 792738.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 211664.4 мянган төгрөгөөр бууруулж 581073.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 581073.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 557207,4 мянган төгрөг зарцуулж 16285,7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 7580.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Байр ашиглалттай холбоотой зардал 2002.9 мянган төгрөг, шатахууны зардал 1052.4 мянган төгрөг, урсгал зардал 5577.5 мянган төгрөг, НДШ-ийн зардал 1615.5 мянган төгрөг, ковид цар тахалтай холбоотойгоор томилолтын зардал 13593.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд захиалагчийн хяналтын зардал 227525.9 мянган төгрөг төвлөрснөөс хөрөнгөтэй холбоотой 156430.7 мянга, сургалттай холбоотой 7513.5 мянга, , нормын хувцас 500.0 мянга, Ковидтой холбоотой 5540.7 мянга, аудитын актын төлбөр 5060.0 мянга, шагнал урамшуулал, тэтгэмжид 1531.0 мянга нийт 182075.8 мянган төгрөгийг зарцуулж 45500.0 мянган төгрөгийг ГЗБГЗЗГ-т төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулахдаа Барилга хот байгуулалтын яамны 2020.05.06-ны 03/1690, ТӨБЗГ-ын 2020.04.21-ны 169 тогтоол, Аймгийн Засаг даргын А/348 тоот захирамжаар 127700.0 мянга, А/694 тоот захирамжаар 20000.0 мянган төгрөгийн автомашин худалдан авах зөвшөөрөл, ГЗБГЗЗГ-ын 2020.12.07-ны 1/3343, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 85 тушаалыг үндэслэн 9799.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авах зөвшөөрөл, Барилга хот байгуулалтын сайдыг тушаал 2019.04.26 оны 85 тоот тогтоолыг үндэслэн Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын даргын тушаалаар зарцуулагдсан байна. Аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 2,0 сая төгрөг, ГЗБГЗЗГ-аас 3,0 сая төгрөг төвлөрснийг даргын тушаалаар урамшуулалд 3231,0 мянга, түлшний хөнгөлөлтөд 2900,0 мянган төгрөг олгож нэмэлт санхүүжилтийн данснаас 1131,0 мянган төгрөгийг илүү зарцуулсан мөн 4 ажилтанд нэг удаагийн тэтгэмжид 400,0 мянган төгрөгийг нэмэлт данснаас олгож буруу зарцуулсан ба цаашид анхаарч ажиллах.

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
394	ХӨТӨЛБӨР 71504 Газрын зураглал, кадастр	581,073,500.00	557,207,364.42	-23,866,135.58	95.9
395	АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	500,919,000.00	484,652,406.42	16,266,593.58	96.75
398	Бараа, үйлчилгээний зардал	500,919,000.00	484,652,406.42	16,266,593.58	96.75
399	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,478,500.00	406,478,073.66	426.34	100.00
405	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,784,900.00	53,169,354.76	1,615,545.24	97.05
416	Хангамж, бараа материалын зардал	20,334,400.00	19,281,950.00	1,052,450.00	94.82
424	Нормативт зардал	396,000.00	396,000.00	-	100.00
433	Томилолт, зочны зардал	18,340,600.00	4,747,000.00	13,593,600.00	25.88
437	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	584,600.00	580,028.00	4,572.00	99.22
493	АРГА ХЭМЖЭЭ 80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	28,792,900.00	21,212,513.00	7,580,387.00	-
496	Бараа, үйлчилгээний зардал	28,792,900.00	21,212,513.00	7,580,387.00	73.67
509	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,215,400.00	21,212,513.00	2,002,887.00	91.37
526	Эд хогшил худалдан авах	5,577,500.00	-	5,577,500.00	-
591	АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	15,622,600.00	15,622,600.00	-	100.00
592	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,622,600.00	15,622,600.00	-	100.00
660	Бусад урегал шилжүүлэг	15,622,600.00	15,622,600.00	-	100.00
689	АРГА ХЭМЖЭЭ 82404 Барилгын техник хяналт	35,739,000.00	35,719,845.00	19,155.00	99.95
741	Бараа үйлчилгээний бусад зардал	35,739,000.00	35,719,845.00	19,155.00	99.95

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь байршуулж төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 4 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 2, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	11	9	9	0
2	Хагас жил	4	4	4	0
3	Улирал бүр	4	4	4	0
4	Сар бүр	12	36	30	6
5	Тухай бүр	12	96	94	2
	Нийт		149	141	8

Эх сурвалж: Shilendans.gov.mn сайт

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31630.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27031.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 31630.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 27031.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тус газар нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 169-р тогтоол, Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны 03/1690 тоот албан бичгээр захиалагчийн техник хяналтын зардлаас 127700.0 мянган төгрөгөөр суудлын автомашин худалдан авах үнийн дээд хязгаар тогтоосныг зөрчин Аймгийн засаг даргын 2020 оны А/694 тоот захирамжаар 20000.0 мянган төгрөгийг нэмж нийт 147700.0 мянган төгрөгөөр захиалагчийн хяналтын зардлаас суудлын автомашин худалдан авах зөвшөөрөл гаргуулан худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , 14.1."Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна;" , 14.1.8."Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;" , 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" , Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4 дүгээр зүйлийн 30.4.1 "Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай

өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;" тухай заалтууд, санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын 2021 оны барилгын захиалагчийн хяналтын зардлаас 20000.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Автомашины тендерт шалгарсан Индранил-Очир ХХК-нд 2020.08.26-нд автомашины урьдчилгаа санхүүжилтэд 60500.0 мянган төгрөг олгосон ба нийлүүлсэн автомашин тендерийн техникийн шаардлага хангаагүй тул тендерийг цуцалснаас 2020.10.28-ний өдөр 55000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд буцаан шилжүүлж, тайлант хугацааны эцэст 5500.0 мянган төгрөгийн авлагатай гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалт. "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Автомашины урьдчилгааны үлдэгдэл 5500.0 мянган төгрөгийг Индранил-Очир ХХК-аар төлүүлэх төлбөрийн акт тогтоох

3. Аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 2,0 сая төгрөг, ГЗБГЗЗГ-аас 3,0 сая төгрөг төвлөрснийг даргын тушаалаар урамшуулалд 3231,0 мянга, түлшний хөнгөлөлтөд 2900,0 мянга, 4 ажилтанд нэг удаагийн тэтгэмжид 400,0 мянган төгрөгийг төгрөг олгож нэмэлт санхүүжилтийн данснаас нийт 1531,0 мянган төгрөгийг илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалт "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн:Түлшний үнийн хөнгөлөлтийн илүү олгосон 1531,0 мянган төгрөгийг шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

#### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020.04.21-ны өдрийн 169 тоот тогтоол, Барилга, хот байгуулалтын яамны 2020.05.06-ны өдрийн 03/1690 тоот албан бичгээр захиалагчийн техник хяналтын зардлаас Баянхонгор аймгийн ГХБХБГ-т 127700.0 мянган төгрөгийн дээд хязгаарт багтаан суудлын автомашин худалдан авах шийдвэрийг зөрчиж Аймгийн засаг даргын 2020 оны А/694 тоот захирамжаар 20000.0 мянган төгрөгийг нэмж нийт 147700.0 автомашин худалдан авч Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 14.1."Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна:", 14.1.8."Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;", 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" гэсэн заалт, санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020.04.21-ны өдрийн 169 тоот тогтоолоор тогтоосон дээд хязгаараас 20,0 сая төгрөгийг хэтрүүлэн хөрөнгө худалдан авсан байхад тухайн байгууллагын хөрөнгөд бүртгэх зөвшөөрлийг 2020.11.04-ны өдрийн А-3/1930 албан тоотоор олгосон нь төсвийн төсвийн сахилга бат алдагдаж, тус тогтоолын

хэрэгжилтэд тавих хяналт хэрэгжихгүй байгаа тул энэ асуудлаар ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Илрүүлэлт 1: Аймгийн Засаг даргын 2020.05.19-ны өдрийн А/348 тоот захирамжаар 127700.0 мянган Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2020.05.25-ны өдөр зарласан автомашин худалдан авах тендерт оролцогч ирээгүй, 2020.06.26-нд тендерийг дахин зарлахад Индранил Очир ХХК 121000.0 мянган төгрөгөөр автомашин нийлүүлэхээр шалгарсан ч нийлүүлсэн автомашин техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй тул захиалагч тендерээс татгалзсан бөгөөд Аймгийн засаг даргын 2020 оны А/694 тоот захирамжаар 20000.0 мянган төгрөгийг нэмж ТӨБЗГ-ын 2020.04.21-ны өдрийн 169 тоот тогтоолоор худалдан авалтад хязгаар тогтоосон дээд хэмжээг хэтрүүлэн нийт 147700.0 мянган төгрөгөөр захиалагчийн хяналтын зардлаас суудлын автомашин худалдан авах зөвшөөрөл гаргуулж худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй "Таван богд" ХХК-аас шууд худалдан авалт хийсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 14.1."Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна," 14.1.8."Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн," 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4 дүгээр зүйлийн 30.4.1 "Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах," тухай заалтууд, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

Эрсдэл: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин худалдан авах үнээс илүү үнээр худалдан авалт хийх, төсвийн хөрөнгийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулахгүй үрэлгэн байх, өөрийн хууль бус үйлдэл, хариуцлагаас зайлсхийх, зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж залилах;

Өгсөн зөвлөмж: Цаашид:

- Төсвийн шууд захирагчийн үүргийг хэрэгжүүлэхдээ Төсвийн болон холбогдох хуульд нийцүүлэн, Төрийн албаны хуульд заасны дагуу хийсэн ажлынхаа үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээж ажиллах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн биелүүлэх талаар анхаарч ажиллан, барилга захиалагчийн хяналтын зардлыг журмын дагуу үр ашигтай, үр дүнтэй зарцуулж, үр дүнгийн хэрэгжилтийг тухай бүр нь холбогдох дээд байгууллагад мэдээлж байх;

**Байгууллагаас өгсөн хариу:** Баянхонгор аймгийн ГХБХБГ-аас 2021.02.24-ны өдрийн 101 тоот албан бичгээр санхүүгийн аудиттай холбогдон ирүүлсэн тайлбар нь хууль, стандарттай нийцэхгүй байгаа тул стандартын дагуу "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөв.

**Тайлбар:** Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын дарга Д.Алтангэрэл даргаас ирүүлсэн тайлбар нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд нийцэхгүй байгаа тул хүлээн авах боломжгүй болно.

## **2.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

Илрүүлэлт2: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Баянхонгор аймгийн Засаг даргатай байгуулсан 2020.04.14-ны өдрийн 2020/09 тоот “Улсын болон орон нутгийн төсвөөс барилга, байгууламжид хяналт тавих, хяналтын зардлыг зарцуулах, хамтран ажиллах гэрээ” ний дагуу улсын төсвийн болон ОНТХО-ын захиалагчийн хяналтын зардлын тооцоог хийгээгүй байсан ба 2021.02.23-ны өдөр аймгийн ХБХОТХ-ийн мэргэжилтэнтэй тооцоо нийлж барилгын захиалагчийн хяналтын зардал 4123.6 мянган төгрөгийн авлагатайг баталгаажуулсан, тайланд тусгаагүй болно.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэ зөв байх”, 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14,4,2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалт “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Эрсдэл: Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулахгүй байх

Өгсөн зөвлөмж:

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Баянхонгор аймгийн Засаг даргатай байгуулсан 2020.04.14-ны өдрийн 2020/09 тоот “Улсын болон орон нутгийн төсвөөс барилга, байгууламжид хяналт тавих, хяналтын зардлыг зарцуулах, хамтран ажиллах гэрээ”-ний дагуу хяналт тавьж ажилласан барилга байгууламжийн хяналтын зардлын тооцоог санхүүгийн жилд багтаан нийлж өглөг, авлагыг баталгаажуулан бүртгэлд бүрэн тусгаж байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Илрүүлэлт3: Авто тээврийн 11-66 БНХ улсын дугаартай Toyota landcruiserx76i, 12-28 БНР улсын дугаартай Toyota Prius суудлын автомашинуудыг мэргэжилтнүүд ашигладаг. Харин 10-76 БНН Toyota landcruiser 200 автомашиныг ГХБХБГ-ын дарга албан хэрэгцээнд болон хөдөө томилолтоор явахад зориулан ашиглаж байгаа ба замын тооцооны хуудсаар аймаг дотор албан ажлаар 150 км, онцгой байдлын ерөнхий эргүүлийн ажлаар явж 1270 км-т 476,1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тушаалын 8 дахь заалтыг зөрчсөн байна. Мөн Аймгийн Засаг даргын 2020 оны А/409 тоот захирамжаар баталсан автомашин ашиглалтын журмын 4.7-дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл: Суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан хаагч албан тушаалын болон албан ажлын автомашин зориулалтын бусаар хэрэглэж, зардал гаргасан байх.

Өгсөн зөвлөмж.

- Суудлын автомашиныг албан хэрэгцээнд ашиглахдаа Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тушаалын 8 дахь заалтыг хэрэгжүүлэн аймаг дотор 2500 цилиндрээс доош багтаамжтай автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж, шатахуун зарцуулалтын нормативыг мөрдөж, Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын логог Аймгийн Засаг даргын 2020 оны А/409 тоот захирамжаар баталсан автомашин ашиглалтын журмын дагуу байршуулах.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт4: Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь байршуулж төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 4 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 2, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Эрсдэл: Шилэн дансны мэдээллийн үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулаагүй байх

Өгсөн зөвлөмж:

- Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>1</sup>, 7.1.3<sup>2</sup> заалтын дагуу шилэн дансанд мөн хуулийн 6 дугаарт заасан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР ..... М.АЛТАНТУЯА  
ОГНОО: 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР ..... А.ЦЭЭНЯМ  
ОГНОО: 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР ..... Б.МӨНХБАТ  
ОГНОО: 2021.02.25

<sup>1</sup> Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ:

<sup>2</sup> тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/38/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар		Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
	1	2	3	Албан тушаал	Овог нэр
				4	5
1	Аймгийн Засаг даргын 2020.05.19-ны өдрийн А/348 тоот захирамжаар 127700.0 мянган Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2020.05.25-ны өдөр зарласан автомашин худалдан авах тендерт оролцогч ирээгүй, 2020.06.26-нд тендерийг дахин зарлахад Индранил Очир ХХК 121000.0 мянган төгрөгөөр автомашин нийлүүлэхээр шалгарсан ч нийлүүлсэн автомашин техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй тул захиалагч тендерээс татгалзсан бөгөөд Аймгийн засаг даргын 2020 оны А/694 тоот захирамжаар 20000.0 мянган төгрөгийг нэмж ТӨБЗГ-ын 2020.04.21-ны өдрийн 169 тоот тогтоолоор худалдан авалтад хязгаар тогтоосон дээд хэмжээг хэтрүүлэн нийт 147700.0 мянган төгрөгөөр захиалагчийн хяналтын зардлаас суудлын автомашин худалдан авах зөвшөөрөл гаргуулж худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй "Таван богд" ХХК-аас шууд худалдан авалт хийсэн.	20000.0	Зөвлөмж өгөх, Санхүүгийн тайланд "Хязгаарлалттай дүгнэлт" өгөх	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Алтангэрэл, С.Гэрэлмаа
2	ТӨБЗГ-ын 2020.04.21-ны өдрийн 169 тоот тогтоол, Барилга, хот байгуулалтын яамны 2020.05.06-ны өдрийн 03/1690 тоот албан бичгээр захиалагчийн техник хяналтын зардлаас Баянхонгор аймгийн ГХБХБГ-т 127700.0 мянган төгрөгөөр тогтоосон суудлын автомашин худалдан авах үнийн дээд хязгаарыг зөрчсөн.		Төлбөрийн акт тогтоох Санхүүгийн тайланд "Хязгаарлалттай дүгнэлт" өгөх	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Алтангэрэл, С.Гэрэлмаа
3	Автомашин тендерт шалгарсан Индранил-Очир ХХК-нд 2020.08.26-нд автомашины урьдчилгаа санхүүжилтэд 60500.0 мянган төгрөг олгосон ба нийлүүлсэн автомашин тендерийн техникийн шаардлага хангаагүй тул тендерийг цуцалснаас 2020.10.24-өдөр 55000.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансаар орж тайлант хугацааны эцэст 5500.0 мянган төгрөгийн авлагатай гарсан.	5,500.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Алтангэрэл, С.Гэрэлмаа
4	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Баянхонгор аймгийн Засаг даргатай байгуулсан 2020.04.14-ны өдрийн 2020/09 тоот "Улсын болон орон нутгийн төсвөөс барилга, байгууламжид хяналт тавих, хяналтын зардлыг зарцуулах, хамтран ажиллах гэрээ" ний дагуу улсын төсвийн болон ОНТХО-ын захиалагчийн хяналтын зардлын тооцоог хийгээгүй байсан ба 2021.02.23-ны өдөр аймгийн ХБХОТХ-ийн мэргэжилтэнтэй тооцоо нийлж барилгын захиалагчийн хяналтын зардал 4123.6 мянган	4,123.6	Зөвлөмж өгөх	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Алтангэрэл, С.Гэрэлмаа

	төгрөгийн авлагатайг баталгаажуулсан, тайланд тусгаагүй болно.				
5	1. Авто тээврийн 11-66 БНХ улсын дугаартай Toyota landcruiserix76i, 12-28 БНР улсын дугаартай Toyota Prius суудлын автомашинуудыг мэргэжилтнүүд ашигладаг. Харин 10-76 БНН Toyota landcruiser 200 автомашиныг ГХБХБГ-ын дарга албан хэрэгцээнд болон хөдөө томилолтоор явахад зориулан ашиглаж байгаа ба замын тооцооны хуудсаар аймаг дотор албан ажлаар 150 км, онцгой байдлын ерөнхий эргүүлийн ажлаар явж 1270 км-т 476,1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тушаалын 8 дахь заалтыг зөрчсөн байна. 2. Аймгийн Засаг даргын 2020 оны А/409 тоот захирамжаар баталсан автомашин ашиглалтын журмын 4.7-дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.	476.1	Зөвлөмж өгөх	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Алтангэрэл, С.Гэрэлмаа
6	Аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 2,0 сая төгрөг, ГЗБГЗЗГ-аас 3,0 сая төгрөг төвлөрснийг даргын тушаалаар урамшуулалд 3231,0 мянга, түлшний хөнгөлөлтөд 2900,0 мянга, 4 ажилтанд нэг удаагийн тэтгэмжид 400,0 мянган төгрөгийг төгрөг олгож нэмэлт санхүүжилтийн данснаас нийт 1531,0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байгаа тул түлшний үнийн хөнгөлөлтийг суутган тооцож төсөвт төвлөрүүлэх, мөн өөрийн орлогоор 14.0 сая төгрөг төвлөрч аймгийн Төрийн санд хүсэлт өгч зарцуулсан байгаа ба цаашид нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогыг эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зарцуулж байхад анхаарч ажиллах.	1531.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Алтангэрэл, С.Гэрэлмаа
7	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь байршуулж төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 4 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 2, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Д.Алтангэрэл, С.Гэрэлмаа
<b>ДҮН</b>		<b>31630.7</b>			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_